

## САНХҮҮ БҮРТГЭЛИЙН ТАСГИЙН ТАНИЛЦУУЛГА

Орхон аймгийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн Санхүү, бүртгэлийн тасаг нь “Бид даатгуулагчдынхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэнэ” гэсэн эрхэм зорилгын дор нэгдэн хэлтсийн санхүү, бүртгэлийн үйл ажиллагааг Монгол улсын хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн явуулж Орхон аймгийн 2000 гаруй аж ахуйн нэгж байгууллага, давхардсан тоогоор 250 гаруй мянган даатгуулагчид хүрч ажиллан эрүүл мэнд, нийгмийн даатгалын үйлчилгээ үзүүлж, 67.4 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, 74.2 тэрбум төгрөг зарцуулах зардлын төсөвтэйгээр үйл ажиллагаа явуулж буй үндсэн тасаг юм.



Үйл ажиллагаандаа Нийгмийн даатгалын тухай хуулиуд, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомжоор олгосон эрх, үүргийн хүрээнд нийгмийн даатгалын сангийн санхүүгийн үйл ажиллагааг зохион байгуулж хяналт тавих үндсэн чиг үүрэгтэй. Санхүү, бүртгэлийн тасагт:

- Тасгийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч
- Сангийн нягтлан бодогч
- Төлөвлөлт, судалгаа шинжилгээ нэрийн дансны тооцоо хариуцсан мэргэжилтэн
- Байгууллагын үйл ажиллагааны нягтлан бодогч
- Хуулийн зөвлөх, хүний нөөцийн ажилтан
- Эд хөрөнгө хариуцсан ажилтан
- Хэлтсийн жолооч
- Үйлчлэгч гэсэн 8 орон тоотой ажиллаж байна.

Нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, мэдээллийн сангийн бүрдүүлэлт, урсгал болон хөрөнгө оруулалтын батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах холбогдох мэдээ, тайланг бэлтгэн хянаж, нэгтгэн холбогдох байгууллагуудад хүргүүлэх, сангуудын орлого, зарлагын болон үйл ажиллагааны хөрөнгө оруулалтын зардлын жилийн төсвийн төсөл, төсөөллийг боловсруулах, төлөвлөх, судалгаа шинжилгээг гүйцэтгэж, тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны талаарх мэдээллийг даатгуулагч, иргэдэд хүргэх, ЭМНД-ын менежментийг боловсонгүй болгож, үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж, үр дүнг үнэлэх ажлыг зохион байгуулан байгуулж байна.